15. Саланайн Мандат - Баян-Өлгий аймгийн Байгаль орчны албаны ахлах мэргэжилтэн

16. Бүлтэгийн Мөнхбат - Баянхонгор аймгийн Шинэжинст сумын холбооны салбарын эрхлэгч

17. Нямдагвын Мэндбаяр - Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны ахлах мэргэжилтэн

18. Чулууны Мягмаржав - Нийслэлийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн өмгөөлөгч

19. Жумуугийн Нарантуяа - Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн хүн эмнэлгийн бага эмч, алтөхийн эрхлэгч

20. Самдангийн Нарантуяа - ЭМШУИС-ийн эрдэм шинжилгээ, гадаад харилцаа хариуцсан дэд захирал

21. Доржнамжмын Наранцэцэг - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн нягтлан бодогч

22. Содномын Нармандах - Зэвсэгт хүчний Клиникийн төв госпиталийн сувилагч

23. Жанчигийн Нумандарь - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн хүнсний нярав

24. Ноосойн Нямбай - Зэвсэгт хүчний Клиникийн төв госпиталийн нөхөн сэргээх эмчилгээний их эмч

25. Цэрэнгийн Отгонжаргал - Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын кино механик

26. Ойдовжамцын Оюун - Булган аймгийн 11 жилийн 1 дүгээр сургуулийн бага ангийн багш

27. Жамбаахүүгийн Оюунбилэг - Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн бичээч оператор

28. Өлзийбатын Оюунбилэг - БХЯ-ны Санхүүгийн хэлтсийн нягтлан бодогч

29. Мөнхжаргалын Өсөхбаяр - "Мон-Алтиус" биеийн тамирын дээд сургуулийн дэд захирал

30. Очирын Пашка - Булган аймгийн 11 жилийн 1 дүгээр сургуулийн математикийн багш

31. Пүрэвийн Пашка - Булган аймгийн Дашинчилэн сумын 10 жилийн сургуулийн бага ангийн багш, сургалтын менежер

32. Намдагийн Пүрэвсүрэн - Архангай аймгийн Эрдэнэмандал сумын дунд сургуулийн мэдээлэл зүйн багш

33. Намхайн Рагчаахүү - ҮТЕГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн татварын улсын байцаагч

34. Хинаятын Ром - Баян-Өлгий аймгийн Байгалийн голомтод халдварт өвчинтэй тэмцэх газрын лаборант

35. Балаубайн Саныха - Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн нярав

36. Авирмэдийн Сарантуяа - ТЕГ-ын Хангалт үйлчилгээний хэлтсийн үйлчлэгч

37. Халайн Сулушаш - Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын Архивын албаны дарга

38. Данаагийн Төмөр - ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн аж ахуйн эрхлэгч

39. Малкейн Уатхан - Баян-Өлгий аймгийн Татварын хэлтсийн улсын байцаагч

40. Балжирын Уртнасан - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ЗДТГ-ын бичээч, бичиг хэргийн эрхлэгч

41. Забайн Ханат - Баян-Өлгий аймгийн Алтай сумын ахлах сургуулийн сургалтын менежер

42. Лхагважавын Цэвэгжав - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн номын санч, нярав

43. Оросоогийн Цэвэгсүрэн - Уул уурхайн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

44. Довдонгийн Цэндсүрэн - Нийслэлийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн өмгөөлөгч

45. Цогтын Цэцэгмаа - Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн холбооны төвийн сүлжээний техникч

46. Дамчаагийн Цэцэгзэ - Баян-Өлгий аймгийн Буянт сумын ахлах сургуулийн сургалтын менежер

47. Чимэдрэгзэнгийн Чүлтэм - Зэвсэгт хүчний Ар тал, техникийн хангалтын албаны нярав

48. Хургаагийн Энхтайван - Монголын Өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгч

49. Бавуугийн Энхтуяа - Монголын нотариатчдын танхимын нотариатч



50. Тардаагийн Энхцэцэг - БХЯ-ны харьяа Цэргийн дүрэмт хувцасны "Бөртэ" ТӨҮГ-ын оёдолчин

51. Цэвэлхүүгийн Эрдэнэ-Очир - Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн

52. Данзанямын Эрдэнэчимэг - Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний

тэргүүлэх ажилтан

53. Үдэвийн Эрдэнэчимэг - Зэвсэгт хүчний нэгдсэн лабораторийн химич инженер

54. Цогбадрахын Эрдэнэчулуун - Орхон аймгийн "Маргад" дээд сургуулийн ерөнхий захирал

55. Дэчингийн Эсмээндорж - ТЕГ-ын Хангалт үйлчилгээний хэлтсийн засалчин

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Санжаадоржийн Амаржаргал - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн техник шалгах байрны дарга, ахлах ахлагч

2. Батсүхийн Арвинбилэг - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн орон сууц, шатахууны дарга, хошууч

3. Жанцандоржийн Ариунбилэг - Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн кино радио механикч, жолооч ахлах ахлагч

4. Батаагийн Баатарсүх - Төрийн холбооны газрын кабельчин, ахлах ахлагч

5. Төмөрчөдөрийн Бавуудорж - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн батарейны захирагч, ахмад

6. Доржготовын Бадрал - Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 017 дугаар ангийн техникч, ахмад

7. Банзайн Балжинням - Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн штабын даргын орлогч, дэд хурандаа

8. Дармаагийн Батдорж - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн салааны захирагч, жолооч ахлах ахлагч

9. Цахлайсүрэнгийн Батжаргал - Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 110 дугаар салбарын захирагч, хошууч

10. Цэрэнсодномын Батнамсрай - Хилийн 286 дугаар ангийн заставын сэтгэл зүй эрхэлсэн орлогч, хошууч

11. Дондовдоржийн Бат-Өлзий - ТЕГ-ын дээд сургуулийн тэнхмийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч, дэд хурандаа

12. Дагвын Баттөр - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн химийн бүлгийн дарга, ахмад

13. Далхжавын Бат-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн батальоны ахлагч, жолооч, сургагч ахлагч

14. Лхагвын Бат-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн ар талын даргын орлогч, авто техникийн дарга, дэд хурандаа

15. Самдангийн Бямбасүрэн - ЦДС-ийн ар талын тэнхмийн багш, дэд хурандаа

16. Дамдины Баяр - ТЕГ-ын 2 дугаар газрын ахлах ажилтан, хошууч

17. Ишжамцын Баярмагнай - ЦДС-ийн артиллер зэвсгийн тэнхмийн багш, дэд хурандаа

18. Лувсандоржийн Баярцогт - ЗХ-ний авто техникийн хяналтын дарга, дэд хурандаа

19. Түүвэнгийн Баянхишиг - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн станцын дарга, жолооч, ахлах ахлагч

20. Пунцогнамжилын Болор - ХХЕГ-ын шуурхай дүн шинжилгээний албаны шуурхай жижүүр, хошууч

21. Содномдаржаагийн Буянжаргал - Зэвсэгт хүчний Клиникийн төв госпиталийн дүрслэл оношлогооны тасгийн дарга, дэд хурандаа

22. Загдын Галбаатар - Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн дамжин өнгөрүүлэх байрны дарга, ахмад

23. Пагважавын Ганбаатар - Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн захирагчийн орлогч, дэд хурандаа

24. Ранжингийн Ганбаатар - Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн цаг уурын хөдөлгөөнт станцын дарга, ажиглагч жолооч, ахлах ахлагч

25. Дамбийжанцангийн Ганбат - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн сургалт, цэргийн албаны ахлах офицер, хошууч

26. Доржийн Ганбат - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн байлдааны хангалтын хэрэгслийн агуулахын дарга, хошууч

27. Бадарчийн Ганболд - Хилийн 0164 дүгээр ангийн захирагчийн орлогч, дэд хурандаа

28. Хаажаагийн Гантөмөр - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн цехийн дарга, дэд хурандаа

29. Самбуугийн Гантөмөр - Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн кабельчин, жолооч ахлах ахлагч

Засгийн газрын 2008 оны 12 дугаар
тогтоолын 1 дүгээр хэсэрлэлт

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БӨӨНИЙ ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ КОМПАНИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэх, улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний хомсдол үүсч, үнийн хөөрөгдөл гарахаас урьдчилан сэргийлэх, улсын эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн нөөц (цаашид "компанийн нөөц" гэх) -ийг бүрдүүлэх, түүний хадгалах, сэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Энэхүү журмыг газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид "тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх) дагаж мөрдөнө.

Хоёр. Компанийн нөөц бүрдүүлэлт

3. Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн нөөцийг заавал бүрдүүлнэ.

4. Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь компанийн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, байршил, тусгасан гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулна. Гэрээний үлгэрчилсэн загварыг газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Засгийн газрын шийдвэр гарсан өдрөөс хойш хоёр сарын дотор компанийн нөөцийг тогтоосон нэр төрөл, хэмжээгээр өөрийн эзэмшлийн агуулахад бүрдүүлэн, цаашид заасан хугацаанд сэлгээ хийж хадгална.

6. Компанийн нөөцөд дор дурдсан байдлаар хадгалагдаж байгаа газрын тосны бүтээгдэхүүн орохгүй:

6.1. Савнаас гарахгүй үлдэгдэл бүтээгдэхүүн;

6.2. Дамжуулах хоолой дахь бүтээгдэхүүн;

6.3. Гаалийн баталгаат агуулахад хадгалагдаж байгаа бүтээгдэхүүн.

Гурав. Компанийн нөөцийн хэмжээ

7. Компанийн нөөцийн нэр төрөл, хэмжээ, сэлгээ хийх хугацааг тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн 10 дугаар сард тогтооно.

8. Тухайн жилийн явцад шинээр тусгай зөвшөөрөл авсан этгээдийн бүрдүүлэх компанийн нөөцийн байршил, хэмжээ, сэлгээ хугацааг газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага түр тогтооно.

9. Компанийн нөөцийг тогтоохдоо газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн өмнөх онд импортоор оруулсан буюу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг үндэслэн газрын тосны бүтээгдэхүүний төрөл тус бүрээр нь тооцно.

Дөрөв. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь чанар, стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүнээр компанийн нөөцийг бүрдүүлэх, технологийн дагуу хадгалах үүргийг хүлээнэ.

11. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн нөөцөд байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг Даатгалын тухай хуулийн 5.1, 17.1-д заасны дагуу даатгуулна. Даатгалын хураамжийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

12. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн нөөц бүрдүүлэх, хадгалах болон компанийн нөөцөд хадгалагдаж байгаа газрын тосны бүтээгдэхүүний хадгалалтын үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг чанд мөрдөн ажиллаж, гарах зардал, эрсдэлийг бүрэн хариуцна.

13. Зах зээлийн тухайн үеийн нөхцөл байдлыг үндэслэн компанийн нөөцийг зөвхөн Засгийн газрын гаргасан шийдвэрийн дагуу борлуулна. Засгийн газрын шийдвэр гарсан өдрөөс холбогдох хууль тогтоомжид заасны дагуу газрын тосны бүтээгдэхүүний онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татварыг төлнө.

14. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн нөөц бүрдүүлэх үүргээ бусдаар төлөөлүүлэн гүйцэтгүүлэх, эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад компанийн нөөцийн тогтоосон байршлыг өөрчлөх, нөөцийг өөр зорилгоор ашиглах, зарцуулахыг хориглоно.

Тав. Мэдээ, тайлан

15. Компанийн нөөцийн мэдээ, тайлан гаргах маягтыг газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

16. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн нөөцийн талаархи сарын мэдээ, тайланг дараа сарын 5-ны дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор гарган газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон улсын мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлнэ.

17. Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн сарын мэдээ, тайланг нэгтгэн сар бүрийн 15-ны дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны дотор санхүүгийн болон газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

18. Импорт ороулж байгаа газрын тосны бүтээгдэхүүний сар, жилийн мэдээ, тайланг Улсын

гаалийн ерөнхий газар тусгай зөвшөөрөл эзэмшигч нэг бүрээр гаргаж газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон улсын мэргэжлийн хяналтын байгууллагад сар бүрийн 15-ны дотор хүргүүлж байна.

Зургаа. Хяналт тавих

19. Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй компанийн нөөц бүрдүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавьж санхүүгийн болон газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад мэдээлж байна.

20. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Стандартчилал, хэмжил зүйн төвөөс баталсан "Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн технологи, үйл ажиллагааны аргачлал" стандартын дагуу компанийн нөөцийн хэмжээ, чанарын шенкилгээг хийж бүртгэл хөтөлнө.

21. Засгийн газрын шийдвэрээр тогтоосон компанийн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, сэлгээ хийх хугацаа, бүтээгдэхүүний чанарт газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

Засгийн газрын 2008 оны 12 дугаар тогтоолын 2 дугаар хэсвэрлэл

2008 ОНД КОМПАНИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ, СЭЛГЭЭ ХИЙХ ХУГАЦАА

№	Аж ахуйн нэгжийн нэр	Савны багтаамж (тонн)	Бүрдүүлэх 20 хоногийн нөөцийн хэмжээ (нэр төрлөөр, тонн)				
			А-80	Дт	АИ-92	ТС-1	Дүн(тонн)
1	НИК ХК	81162.0	2450.0	3400.0	550.0	100.0	6500.0
2	Петровис ХХК	2120.0	1800.0	3800.0	2500.0	100.0	8200.0
3	Магнай трейд ХХК	19054.0	4000.0	4800.0	2900.0	200.0	11900.0
4	Шунхлай групп ХХК	5077.0	1150.0	1750.0	800.0	150.0	3850.0
5	Сод Монгол групп ХХК	1219.0	800.0	1400.0	700.0	150.0	3050.0
6	Жаст-Ойл ХХК	7950.0	1000.0	2600.0	700.0		4300.0
7	Ойн бирж ХХК	2618.0	200.0	250.0	250.0		700.0
8	А-ЖЕТ ХХК	2443.0				1500.0	1500.0
НИЙТ ДҮН			11400.0	18000.0	8400.0	2200.0	40000.0
Сэлгээ хийх хугацаа			3 сар	6 сар	3 сар	3 сар	-

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Агаарын бохирдлыг бууруулах талаар ойрын хугацаанд авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нүүрсийг дулааны аргаар боловсруулан коксон түлш үйлдвэрлэх ажлыг эрчимжүүлж, 2009 оны 8 дугаар сараас Улаанбаатар хотын гэр хорооллын хэрэгцээнд болон халаалтын зууханд коксон түлш нийлүүлэх ажлыг зохион байгуулахыг Түлш, эрчим хүчний сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

2. Стандартын шаардлага хангасан, чанарын өндөр үзүүлэлттэй коксон түлшний үйлдвэрлэлийг төрөөс хөхиулэн дэмжих, эдийн засаг, татварын хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэх талаар санал боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэхийг Сангийн сайд Ч.Улаан, Түлш, эрчим хүчний сайд Ч.Хүрэлбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил нарт даалгасугай.

3. Түүхий нүүрсний хэрэглээнээс татгалзан коксон түлшийг хэрэглэгчдэд хүргэх, түгээх зорилгоор борлуулалтын сүлжээ цэг байгуулах, коксон түлшний хэрэглээний онцлог, давуу талыг таниулах, сурталчлах арга хэмжээ авч ажиллахыг Түлш, эрчим хүчний сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчны сайд Г.Шийлэгдамба, Нийслэлийн Засаг дарга Т.Билэгт нарт тус тус үүрэг болгосугай.

4. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх

бүсчлэлийг тогтоож, их, бага тойруугийн нутаг дэвсгэр болон орон сууцны хороололд нүүрс түлэх, хог хаягдлыг ил шатаах явдлыг 2008 оны I улирлаас эхлэн таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга Т.Билэгтэд даалгасугай.

5. Зам, тээвэр аялал жуулчлалын сайд Р.Раш, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, Байгаль орчны сайд Г.Шийлэгдамба нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай:

алнийтийн тээврийн хөгжлийн ойрын болон дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулан баталж, автотээврийн хэрэгслээс ялгарах хорт утаанд хэмжилт хийх явуулын станц ажиллуулах арга хэмжээ авах;

б)утаа их ялгаруулдаг автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон насжилтаас хамааруулан автотээврийн хэрэгслийн онцгой албан татварыг тогтоох зэрэг хөшүүргийн механизм хэрэглэхэд чиглэсэн эрх зүйн орчин бүрдүүлэх талаар санал боловсруулах.

6. "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 17 дугаар хэвсрэлтэд дор дурдсан агуулга бүхий 48 дахь заалтыг нэмсүгэй.

48.	Агаарын бохирдлыг бууруулах талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдан зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хороо	Түлш, эрчим хүчний сайд
-----	---	-------------------------

 МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

 ТҮЛШ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сангийн яамны зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 2004 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 242 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын "...төсвийн нэгтгэлийн хэлтэстэй" гэснийг "төсвийн нэгтгэлийн хэлтэс, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн ажлын албатай" гэж өөрчлөн найруулсугай.

2. Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээний найдвартай ажиллагааг хангах шаардлагыг харгалзан Сангийн яамны мэдээллийн технологийн хэлтсийн ажилтны орон тоог 8-аар нэмэгдүүлсүгэй.

3. Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн ажиллагааг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт нэгдсэн журмаар тусган санхүүжүүлж, Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээний ашиглалтын заавар, журмыг 2008 оны I улиралд багтаан баталж мөрдүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

4. "Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай" Засгийн газрын 2002 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 101 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн тооны нормативыг баримтлан Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон сумдын

Засаг даргын тамгын газарт төрийн сангийн мэргэжилтэн бөгөөд нягтлан бодогчийг ажиллуулахыг сумын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

5. Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээний төрийн сангийн, төсвийн, санхүүгийн тайлангийн, худалдан авах ажиллагааны, эзэл тусламжийн, өрийн удирдлагын мэдээллийн системүүдийн сервер компьютер, программ хангамж, нууцлал, аюулгүй байдал, тэдгээрийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг найдвартай хангах, түүнд хяналт тавих, улмаар нэгдсэн сүлжээний үйл ажиллагааг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтаар хангах, үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг Сангийн яам, уг сүлжээнд холбогдсон бүх шатны төсвийн байгууллагын эцсийн хэрэглэгчийн компьютерийн санхүүгийн программ хангамжаас бусад үйл ажиллагааг хэвийн хангах, түүнд засвар, үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг тухайн байгууллага тус тус хариуцан гүйцэтгэж байхаар тогтоосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтэц батлах тухай" Засгийн газрын 2006 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 36 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн "Сангийн яам-126" гэснийг "Сангийн яам-142" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
САНГИЙН САЙД

С.БАЯР
Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хувиараа ашигт малтмал олборлож байгаа зарим иргэдийн алтны үндсэн ордын хүдрийг баяжуулах үйл ажиллагааг 3-4 газарт

туршилтын хэлбэрээр төвлөрүүлэн зохион байгуулах, шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг судалж хэрэгжүүлэх арга хэмжээ авч, шаардлагатай бол асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг

Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүүд үүрэг болгосугай.

2. Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн бүртгэлийг зохион байгуулж, хамтран ажиллах гэрээтэй ажиллуулах, олборлосон бүтээгдэхүүний тоо хэмжээг бодитойгоор тооцох, зохион байгуулалттай худалдан авах арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү нарт даалгасугай.

3. Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийг нийгмийн даатгал, эмнэлгийн үйлчилгээнд хамруулах, хүүхдийг нь сургах талаар санал боловсруулж хэрэгжүүлэх, нийгмийн хэв журмыг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэл, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Жирэмсэн эмэгтэй, насанд хүрээгүй хүүхэд хувиараа ашигт малтмал олборлож байгаа явдлыг хориглож эрүүл амьдрахын ач холбогдлыг сурталчлан ойлгуулах арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Иргэд хувиараа ашигт малтмал олборлож байгааг зохицуулах чиглэлээр журам болон дэд хөтөлбөрийн төсөл боловсруулж Засгийн газарт 2008 оны 3 дугаар сарын 1-ний дотор оруулахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүүд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД**

Х.НАРАНХҮҮ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг баталсугай.

2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Доха хотноо гарын үсэг зурсан "Хөрөнгө оруулалтыг

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хууль, Боловсролын тухай хуулийн 43.2.10 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад сар бүр олгох тэтгэлгийн хэмжээг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 45000 /дечин таван мянган/ төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

1. "Тэтгэлэг олгох тухай" Засгийн газрын 2007 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 294 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлээр тогтоосон Мэргэжлийн

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Н.БОЛОРМАА

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2008 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын 2007 оны 102 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлыг хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд П.Очирбат /илтгэгч/, Ж.Амарсанаа, Д.Мөнхгэрэл, Б.Пүрэвням нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд мэдээлэл гаргагч Нийслэлийн Баянгол дүүргийн 6 дугаар хорооны оршин суугч, иргэн Ч.Өнөрбаяр оролцож, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл, Р.Гончигдорж нар шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй болно.

Хуралдаанаар "Улсын Ерөнхий прокурорын саналыг хэлэлцсэн тухай" Улсын Их Хурлын 2007 оны 102 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцлээ.

Нэг, Нийслэлийн Баянгол дүүргийн 6 дугаар хорооны оршин суугч, иргэн Ч.Өнөрбаяр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

"Улсын Их Хурлаас Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн тогтоохдоо "Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7-ийн "Энэ хуулийн 6.9.1-д зааснаас бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хуулиар хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн шийдвэр гаргаснаараа Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална", мөн зүйлийн 3 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэргэт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэж" гэсэн заалтыг тус тус зөрчин Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн халдашгүй байдалд хууль бусаар халдах боломжийг бүрдүүлж, эрх зүйн буруу жишиг тогтоож байна" гэжээ.

Хоёр, Нийслэлийн Баянгол дүүргийн 16 дугаар хорооны оршин суугч, иргэн П.Өлзийбат Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

"Улсын Их Хурал дээрх тогтоолыг гаргаснаараа шүүх, прокурорын үүрэг гүйцэтгэж үнэн хэрэгтээ тэдгээрийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон гэж дүгнэж болно. Энэ нь Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалттай харшилж байна.

Зүй нь Улсын Их Хурал өөрт нь уг асуудлаар удаа дараа хандаж буй Улсын Ерөнхий прокурорын саналыг үндэслэн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлаар байр сууриа илэрхийлсэн тогтоол гаргах ёстой байсан атал байцаан шийтгэх зарим ажиллагаа явуулах тодорхой заалт өгчээ. Харин энэхүү арга хэмжээг:

-гагцхүү Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлсэн нөхцөлд;

-мөн Улсын Их Хурал "тогтоолоор" бус

харин зохих хуульд заасан журмаар хэрэгжүүлэх

учиртай.

Гэвч Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалд хуульд заасан журмаар бус тогтоолоор халдаж болдог жишиг тогтоосноороо Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн алхам Улсын Их Хурал хийлээ.

Улсын Их Хурал дээрх тогтоолыг хэлэлцэн батлахдаа Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7-г иш үндэс болгожээ. Өөрөөр хэлбэл хуулийн хориглосон заалтыг үндэслэж Улсын Их Хурал зөвшөөрөл олгосноороо Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчиж байна" гэжээ.

Гурав, Улсын Их Хурлын даргын 2008 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 25 дугаар захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл Улсын Их Хурлын Халдашгүй байдлын дэд хорооны даргын хувьд Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"...Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлд заасан Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал бол гишүүнээс эрх, үүргээ саадгүй хэрэгжүүлэх явдлыг хангах баталгаа юм. Парламентын гишүүний халдашгүй байдлын талаар дэлхийн улс орнуудад баримтладаг нийтлэг ойлголт бол парламентын аль нэг танхимын зөвшөөрөлгүйгээр тухайн гишүүний эсрэг эрүүгийн хэрэг үүсгэдэггүй байна.

Энэ жишгээр гишүүнийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хуулиар хориглосон байдаг.

Улсын Ерөнхий прокурор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын Их Хуралд тавихдаа "нэр бүхий гишүүд гэмт хэргэ үйлдсэн эсэхийг нотлох зорилгоор" гэж тодорхойлон зөвхөн "гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэлд нэгжлэг, баримт бичгүүдэд үзлэг хийх шаардлагатай" гэсэн

үндэслэлээр санал тавьсан. Мөн Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө бүрэн эрхийгээ түдгэлзүүлэх шаардлаггүй харин гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэлд үзлэг, нэгжлэг хийхийг сайн дураараа зөвшөөрсөн хүсэлтийг Улсын Ерөнхий прокурорт тэр үед хандаж бичгээр гаргасан. Ерөнхий прокурорын тавьсан саналын үндсийг нь Улсын Их Хурал зөвшөөрч өгсөн.

Ч.Өнөрбаяр, П.Өлзийбат нар эдгээр гишүүдийн бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэнгүй гэсэн санааны үүднээс хуулиас энэ бүрийн ишлэл авч түүнийгээ Үндсэн хууль зөрчсөн мэтээр тайлбарласан нь ойлгомжгүй байна.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо гишүүний халдашгүй байдлыг хамгаалах үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлэхдээ эрхийг түдгэлзүүлэх нэрийн дор гишүүдийг нотлогдоггүй, нотлохоор ажиллаж байгаа үйлдлээр тэднийг хэрэгт холбогдуулан татахыг урьтал болгохгүйгээр, эрхээ хэрэгжүүлэх баталгааг аль болохоор хангаж өгөхүйцээр шийдвэрийг гаргуулахаар санал тавьсан бөгөөд энэ талаар Улсын Их Хурлын гаргасан шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэхгүй.

Гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг урьд нь Улсын Их Хурал тогтоолоор шийдэж байсан, ийм жишиг нэгэнт тогтсон билээ. Үүнийг хууль дээдлээгүй хууль зөрчсөн гэж хэн ч үзэж байгаагүй, ингэж үзэх үндэс ч үгүй юм.

Улсын Их Хурлын 2007 оны 102 дугаар тогтоол бол Улсын Их Хурлын тухай хуулийн гишүүний бүрэн эрхийн баталгаатай холбоотой тодорхой асуудлыг хэрэгжүүлж байгаа эрх зүйн акт юм. Улсын Их Хурал хуулиа хэрэгжүүлэх тогтоол гаргах эрхтэй. Энэ нь хуулиар шийдвэрлэх асуудлыг тогтоолоор шийдвэрлэсэн гэж маргах үндэслэлийг харуулж байна.

Нэг талаас гишүүний халдашгүй байдал, нөгөө талаас бүрэн эрхийн асуудал хоёр тусдаа ойлголт юм. Гишүүний холбогдолтой асуудлаар үзлэг, нэгжлэг хийх нь заавал эрх түдгэлзүүлэх замаар шийдвэрлэгдэх ёстой мэтээр махран чармайж маргаан үүсгэх нь Үндсэн хуулиа зөв хэрэгжүүлэхэд саад болох, түүгээр ч үл барам хортой нөлөө үзүүлэх талтай гэж үзэх үндэс байна.

Улсын Их Хурлын гишүүн Т.Бадамжунай, Г.Занданшатар нарт холбогдох хэргийг саяхан прокуророос хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Хэрэв Улсын Их Хурал энэ 2 гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гаргасан бол сонгогчдын эрх ашиг хохирох, гишүүд "хэлмэгдсэн" байх байлаа.

Ч.Өнөрбаярын "эрх зүйн байдлыг дордуулсан", "халдашгүй байдалд хууль бусаар халдах боломж бүрдүүлсэн" гэж хэлсэн тэй харьцуулбал харин ч эдгээр гишүүд хуулиар олгогдсон бүрэн эрхээ энэ хугацаанд эдэлсэн байна. Хуулийг догматикаар хэрэглэвэл ийм аюултай байж болохыг амьдрал өөрөө харууллаа.

Улсын Их Хурлын гишүүн төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон ард түмний элч мөн

бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг илэрхийлдгийн хувьд үүргээ бүрэн эрхийн хугацаа дуустал хэрэгжүүлэхийг бид чухалд үздэг.

Энэ нь Үндсэн хуулийн энэ талаархи заалтыг хэлбэрэлтгүй сахиж байгаагийн баримт мөн. Бид үүнийг үндэс болгон гишүүдийг сонгосон сонгогчдын төрд төлөөлөх эрхийг аль болохоор хамгаалсан. Ийнхүү Улсын Их Хурлын энэ удаагийн гаргасан шийдвэр нь "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалд хууль бусаар халдах боломжийг бүрдүүлж, тэдний эрх зүйн байдлыг илт дордуулж, эрх зүйн буруу жишиг тогтоосон" гэсэн хийсвэр дүгнэлтэд амьдрал өөрөө бодитой хариу өгөв.

П.Өлзийбат "Улсын Их Хурал шүүх, прокурорын үүрэг гүйцэтгэсэн, үнэн хэрэгтээ үйл ажиллагаанд нь хугацаанд хөндлөнгөөс оролцсон", "байцаан шийтгэх зарим ажиллагаа явуулах тодорхой заалт өгчээ" гэсэн дүгнэлт хийжээ. Асуудлыг ингэж ярих нь утгагүй бөгөөд тэгвэл прокурор өөрөө Улсын Их Хурлыг байцаан шийтгэх ажиллагаанд оролц гэсэн санал тавьсан юм шиг санаа цаана нь гарч байна.

Прокурорын зүгээс гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх санал тавих нь хуулийн дагуу хэнд ч ойлгомжтой, зүй ёсны зүйл. Харин энд асуудлыг тавихдаа "нэр бүхий гишүүнд гэмт хэрэг үйлдсэнийг тогтоох зорилгоор" гэж тодорхой тэмдэглэсэн байгаа. Гэтэл Цэцэг өгсөн П.Өлзийбатын мэдээлэл, Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгох тухай Ч.Өнөрбаярын өргөдлийн агуулгаас үзэхэд мөрдөн байцаалтын шатны ажлыг гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон, тодорхой болсон нөхцөлтэй хугтан, мэдэхгүйдээ, эсхүл мэддэг атлаа зориуд будилж асуудлыг тавьсан байна. Улсын Их Хурлын гишүүний гэм буруутай эсэхийг шүүх тогтоосноор л эрх түдгэлзүүлэх асуудал эцэслэн яригдах нь хэнд ч ойлгомжтой. Харин үзлэг, нэгжлэг хийхдээ гишүүний бүрэн эрхэд халдахгүйгээр шийдвэрлэгдэх арга зам байгааг амьдрал өөрөө харууллаа.

Үндсэн хуулийн заалтыг ишлэл болгон авч гишүүнийг түдгэлзүүлэх шаардлагыг хангасангүй гэж "гоморхон" түүнийгээ Үндсэн хууль зөрчлөө гэдгээр "халхалсан" байдал ч энд ажиглагдаж байна. Тэд бас тал засан гишүүдийн халдашгүй байдлыг дордуулж хундруулсан гэсэн дүр эсгэжээ.

Эдгээр өргөдөл, мэдээлэл нь заавал эрхийг түдгэлзүүлэхийг шаардсан агуулгатай юм. Жишээ нь: П.Өлзийбатын "зүй нь Улсын Их Хурал өөрт нь үл асуудлаар удаа дараа хандаж буй Ерөнхий прокурорын санал, хариуцлагыг иш үндэс болгон зарим гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлаар байр сууриа илэрхийлсэн тогтоол гаргах ёстой..." гэж улаан цайм хэлснээс үзэхэд удаа дараа Их Хурлын гишүүдийн эрхийг түдгэлзүүлсэнгүй гэж Улсын Их Хурлыг зэмлэсэн аястай юм. Хуулиараа мөн "түдгэлзүүлэх эсэхийн" аль нэгээр Улсын Их Хурал өөрөө шийдвэрлэх эрхтэй.

Арчилсан төрийн дархлаа, чадамжийг хомсдуулах бус харин ч гишүүдтэй холбогдсон асуудлаар үнэн мөнийг зөв шударгаар олох, олон



улсын түвшинд ард түмний элч төлөөлөгчдийн эрхийг зөрчдөг улс болж хувирахгүй байх (1999 онд УИХ-ын гурван гишүүний эрхийг түдгэлзүүлсэн нь төдийлөн оноогүй сургамжтайг санах), төрөө улам бэхжүүлэх шаардлага өнөө үед анхаарал татахаар түвшинд байгаа бөгөөд үүнтэй зэрэгцэн гишүүдийн эрх түдгэлзүүлэхийг махрэн чармайх, нэр хүндийг нь гутаах оролдлого цөөнгүй гарч түүнийгээ Үндсэн хууль, бусад хууль зөрчсөн мэтээр халхавчлан тайлбарлах үзэгдэл гарах болсон нь нууц бишээ.

Улсын Их Хурлын 102 дугаар тогтоол бол Үндсэн хууль зөрчөөгүй, харин ч Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх түдгэлзүүлэх, эс түдгэлзүүлэхийн өмнөх шатанд асуудалд нухацтай хандах боломж байгаагийн илэрхийлэл, гишүүдийн бүрэн эрхийн баталгааг хангах талаас хандсан, Үндсэн хуулийн хүрээнд эрх түдгэлзүүлэх, эс түдгэлзүүлэх болон гишүүний бүрэн эрхийн баталгааны асуудлыг тодотгосон, цаашид зөв жишиг тогтоосон шийдвэр болсон юм.

Үндсэн хуулийн цэц энэ асуудлаар маргаан үүсгэсэн нь үндэслэл багатай болохыг тэмдэглэж байна. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэгч тал энэ асуудлаар Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргах юм гэсэн яриа гарах болсон нь асуудалд улс төрийн өнцгөөс хандаж, урьдаас төлөвлөсөн ажиллагаа явагдах юм биш биз гэж эргэлзэхэд хүргэж байгааг дурдах нь төрийн ажил зөв, шударгаар явагдах зарчим гажуудахвий гэж болгоомжилсных буюу гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3-т "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ..."; Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13-т "Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг ...нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналар шийдвэрлэнэ" гэж тус тус зааснаас үзэхэд Улсын Их Хурал Улсын Ерөнхий прокурорын саналыг үндэслэн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг л шийдвэрлэх эрхтэй болох нь тодорхой байна.

2. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаалах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7-д хуульчилсан хирнээ хуулиар хориглосон зохицуулалтыг тогтоолоор зөвшөөрсөн нь Үндсэн хуулийн зөрчлийн шөвгийг агуулж байна.

3. Улсын Их Хурлын 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 102 дугаар тогтоолыг хуулийн

ямар зүйл, заалтыг удирдлага болгон баталсан нь тодорхойгүй, түүнчлэн уг тогтоолыг Улсын Их Хурал баталснаараа Үндсэн хуулиар олгогдсон өөрийн бүрэн эрхээ хэтрүүлсэн гэх үндэслэлтэй байна.

4. Дээрхи тогтоолоор Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг зөвшөөрсөн нь шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцсон гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1. Улсын Их Хурлын 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Улсын Ерөнхий прокурорын саналыг хэлэлцсэн тухай" 102 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална", мөн зүйлийн 3 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Энэхүү тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...Улсын Их Хурлын гишүүн, төр, нам, олон нийтийн байгууллагын албан тушаалтан иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй" гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

3. Улсын Их Хурлын 2007 оны 102 дугаар тогтоолын үйлчлэлийг 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн эхрэн шийдвэрлэсэн тухай харуу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Ж.БЯМБАДОРЖ

ГИШҮҮН

П.ОЧИРБАТ
Ж.АМАНСАНАА
Д.МӨНХГЭРЭЛ
Б.ПҮРЭВНЯМ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хөлөх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265058
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 3